



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 87

Чойбалсан


Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын “ж” дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дорнод аймгийн “Эмэгтэйчүүдийн хөгжил” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган, хэрэгжилтийг ханган, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /М.Бадамсүрэн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



М.ЭНХТӨР

040220187

ДОРНОД АЙМГИЙН “ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨГЖИЛ”-ИЙН ХӨТӨЛБӨР

НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

Дорнод аймагт “Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр” зургаа дахь жилдээ хэрэгжиж байна. Орон нутгийн хөгжилд эмэгтэйчүүдийн эрх тэгш оролцоог хангах, тэдний нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртээх таатай орчныг бүрдүүлэх замаар амьдралын чанарыг сайжруулан хөгжүүлэхэд эмэгтэйчүүдийн хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилгоор 2014 оноос хэрэгжүүлж эхэлсэн хөтөлбөр юм.

Монгол улсад Ядууралд өртөж байгаа хүн амын нөхцөл байдал ялгаатай байна. Жишээлбэл хөдөөд эрэгтэйчүүд, суурин газарт эмэгтэйчүүд илүү ядууралд өртөж, өрхийн тэргүүн нь боловсрол муутай өрхийн 48 хувь нь ядуу байна гэж *“Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хэрэгжилтийн талаар МУ-ын ЗГ-ын ээлжит 8,9 дүгээр илтгэл”*-д дүгнэгдсэн байдаг.

Дорнод аймаг нь сүүлийн жилүүдэд гэр бүлийн хүчирхийллийг бууруулах чиглэлээр нэлээдгүй үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж буй ч гэр бүлийн хүчирхийлэл нь жил бүр 0,1 – 0,5 хувиар өссөн төдийгүй өрх толгойлон ганцаараа амьдарч буй иргэдийн 82 хувь нь өрх толгойлсон эмэгтэйчүүд байгаа зэрэг нь нийгэмд эмэгтэйчүүдийн ялгавартай байдал байсаар байгааг илэрхийлж байна.

Хөдөлмөрийн зах зээлд ажил хөдөлмөр эрхлэх сонирхолтой ажил идэвхтэй хайгч иргэдийн 54.7 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг ба хөдөлмөрт зуучлагдах байдал нь 12.2 хувьтай байна.

Үүнээс үзэхэд хөдөлмөрийн зах зээл дэх эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн оролцооны түвшин ялгаатай байна. Учир нь хүүхэд харах, гэрийн ажил хийх, суралцах, тэтгэвэрт эрт гарах, эмэгтэйчүүдийн эрхэлж болох хөдөлмөрийн эрэлт хэрэгцээ, цалин хөлс зэрэг нь эмэгтэйчүүдийн хувьд хөдөлмөрийн зах зээлээс гарах үндсэн шалтгаан болж байна.

Бид хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн эмэгтэйчүүдийн дуу хоолойг шийдвэр гаргах түвшинд хүргэх зорилгоор “Орон нутгийн хөгжилд эмэгтэйчүүдийн манлайлал” чуулганыг тогтмол зохион байгуулж нийт 3500 эмэгтэйг хамруулж, “Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх” талаар ойлголтыг олон нийтэд түгээн дэлгэрүүлж, иргэдийн ойлголт хандлагын нэмэгдүүлэх хүрээнд нийт давхардан тоогоор 6500 гаруй эмэгтэйчүүдийг хамруулан ажиллах зэрэг томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажилласан ба цаашид залуу болон дундаж насны эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, эмэгтэйчүүдэд зориулсан тэднийг хөгжихөд чиглэгдсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагаануудыг зохион байгуулах хэрэгцээ шаардлага байсаар байна.

Орон нутгийн сонгуульд эмэгтэйчүүдийн сонгогдох байдал, удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувь зэргээс үзэхэд эмэгтэйчүүдийн нийгмийн манлайллыг нийгэмд хүлээн зөвшөөрөх нийгмийн хандлага бэлтгэгдээгүй байна гэж үзэж болох бөгөөд энэ нь эмэгтэйчүүдийн нийгмийн оролцоо, албан тушаалын ахиц дэвшил, ядуурлын түвшинтэй шууд холбогдож байна

ХОЁР. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ:

1. Нийгмийн амьдралд эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш оролцох, хяналт тавих, шийдвэрийг гаргахад тэгш хүртээмжтэй байх боломжийг бүрдүүлнэ.
2. Жендэрийн тэгш байдлыг хангах бодлогыг салбар, орон нутгийн онцлог, эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулна.
3. Шийдвэр гаргагчид, бодлого боловсруулагчид, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээлэл, түүнчлэн бүхий л салбарт эмэгтэйчүүдийн нийгмийн хөгжилд оролцох оролцоог идэвхжүүлнэ.
4. Жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн эмэгтэйчүүдийн санал санаачилгыг дэмжин ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах чиглэлээр нээлттэй, хүртээмжтэй үйл ажиллагаануудыг зохион байгуулна.
5. "Алсын хараа 2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал
6. Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт
7. Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн эмэгтэйчүүдийн санал санаачилгыг дэмжин, ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах чиглэлээр нээлттэй, хүртээмжтэй үйл ажиллагаануудыг зохион байгуулна.

ГУРАВ. ХАМРАХ ХҮРЭЭ:

Аймгийн охид эмэгтэйчүүд хамрагдана.

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Орон нутгийн хөгжилд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, эмэгтэйчүүдэд хууль эрх зүйн болон гэр бүлийн боловсрол олгох, тэдний хөгжлийг дэмжих зорилгоор амьдралын чанарыг сайжруулах, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах болон нийгмийн эрх тэгш харилцааг бий болгоход оршино.

ТАВ. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖИХ ХУГАЦАА:

2021-2024 он дуусталх хугацаанд 4 жилийн турш хэрэгжинэ.

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:

7.1 Эмэгтэйчүүдийн нийгмийн оролцоог дэмжих чиглэлээр:

Бүх шатны удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийн оролцоог хэрэгжүүлэхээр хуульчилсан, түүнийг хэрэгжүүлэн аймаг орон нутгийн сонгуульд эмэгтэйчүүдийг дэвшүүлэн оролцуулдаг ч тэдний өрсөлдөх чадвар, үнэлэмжийг дээшлүүлэхэд олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, улс төрийн манлайллыг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага байсаар байна.

- Сум, орон нутгийн хэмжээнд эмэгтэйчүүд өөрсдийн дуу хоолой, үзэл бодлыг илэрхийлэх боломжийг нэмэгдүүлэх, дэмжих;
- Эмэгтэйчүүд хөгжих, бие биеэсээ суралцаж, нөлөөлөх боломжийг бий болгох
- Улс төрд болон шийдвэр гаргах төвшинд эмэгтэйчүүдийн манлайллын сургалт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Эмэгтэйчүүдэд тулгамдсан асуудлаар сонирхлын бүлэг, клубийн үйл ажиллагааг дэмжих
- Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн нийгмийн оролцоог бодлогын түвшинд дэмжих
- "Охид Монголын ирээдүй" илтгэлийн уралдааныг зохион байгуулж өсвөр насны охидод эх оронч үзэл, монгол эмэгтэйн ариун журамт үүргийн талаар ойлголтыг нэмэгдүүлэх

7.2 Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр:

- Хувиараа хөдөлмөр эрхлэхэд нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх бичил төслүүдийг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа эрхлэхэд шаардагдах ур чадварыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, холбон зуучлах
- Гэртээ хүүхдээ асардаг, гэрийн хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйг өөрсдийн ур чадвар, сонирхол, чадварт тулгуурласан гэрээрээ орлого олох, бизнес эрхлэх боломжийг дэмжих / сургалт, тоног төхөөрөмжийн дэмжлэг/
- Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд тулгамдаж буй бэрхшээлийг тодорхойлж тэднийг чадавхжуулахад анхаарах \Өрх толгойлсон, хөгжлийн бэрхшээлтэй г.м\

5.3. Эмэгтэйчүүд ба гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлээр:

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах замаар гэр бүлийн хүчирхийллийг бууруулах
- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хөгжил, оролцоог хангах
- Сэтгэл зүйн үйлчилгээг өргөжүүлэх /ялангуяа охид, залуу эмэгтэйчүүдэд/
- Гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн боловсрол мэдлэг ойлголт нэмэгдүүлэх
- Бага насны хүүхэдтэй ээжүүдийн ажлын цагт байгууллагын жендэрийн мэдрэмжтэй бодлогыг баримтлах
- Олон нийтэд гэр бүлийн болон жендэрт суурилсан хүчирхийллийн талаар ойлголтыг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулах,
- Сум\баг бүрд "Гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлд зөвлөгөө өгөх төв"-үүдийг бий болгох;
- Ахмад дунд залуу үеийн эмэгтэйчүүдийн холбоог бэхжүүлэх, гэр бүлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, үр хүүхдээ зөв шударга өсгөхөд залуу ээжүүдэд үлгэрлэх явдлыг хөхүүлэн дэмжих

5.4.Эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх чиглэлээр:

- Малчин эмэгтэйчүүдийг БЗХӨ-өөс урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамруулах
- "Эрүүл Монгол ээж" эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг үе шаттай явуулах
- Өсвөр үе, залуу ээжүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох, зөв зохистой хооллолтын сургалт; үйл ажиллагаа зохион байгуулж буй сургалтын төвүүдийг дэмжих
- Хөдөө орон нутгийн эмэгтэйчүүдэд нөхөн үржихүйн боловсрол олгох, БЗХӨ болон хүсээгүй жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн сургалт сурталчилгааг хүргэх, эрт үеийн оношилгоо, алслагдсан баг, сумын эмэгтэйчүүдэд хүрч үйлчлэх эрүүл мэндийн үйлчилгээг тогтмолжуулах

ДОЛОО. ХҮРЭХ ҮР ДҮН:

- Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт дэмжих төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж, зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх нөхцөл, санхүүгийн болон нийгмийн олон талт дэмжлэгүүд сайжирсан байна.

- Эмэгтэйчүүдийн манлайллыг хүлээн зөвшөөрөх олон нийтийн хандлага өөрчлөгдөж, эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшинд ажиллах байдал нэмэгдсэн байна
- Сум орон нутагт ажиллаж амьдарч буй эмэгтэйчүүдийн нийгмийн оролцоо нэмэгдсэн байна.
- Төр, төрийн бус, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирсан байна.
- Эмэгтэйчүүдэд сэтгэл зүй, эрүүл мэнд, нийгмийн олон талт зөвлөгөө мэдээлэл өгөх, сургалт үйл ажиллагаа зохион байгуулах төвүүд бий болсон байна.
- Хөдөөгийн алслагдсан сумбагт амьдарч буй эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн зөвлөгөө, үзлэгийг хүргэж, эрүүл мэндийн боловсрол нэмэгдүүлсэн байна.

НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага арга зүйгээр хангах;

- Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй төрийн болон төрийн бус байгууллагуудыг оролцуулан хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгуулна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төрийн бус байгууллага болон иргэний нийгмийн байгууллагыг сонгохдоо тодорхой шалгуурыг үндэслэн нээлттэй зарлаж орон нутгийн төр төрийн бус иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангана.
- Цаашид жил бүр сонгогдсон байгууллагын хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг үнэлгээнд түшиглэн гэрээ байгуулна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэг нь жил бүрийн 10 дугаар сарын эхний арав хоногт тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэж, ирэх жилийн төлөвлөгөөг гаргахдаа аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг гарган, санхүүжилтийг батлуулан, хэрэгжилтийг удирдан зохион байгуулна.

ЕС. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ:

Улсын төсөв, орон нутгийн төсөв, гадаадын төсөл хөтөлбөр, олон улсын төсөл хөтөлбөр, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгжийн хамтын оролцоо дэмжлэг, хандив.

Цаашид жил бүр хөтөлбөрийн үндсэн чиглэлийн дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөн батлуулах

Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, олон улсын байгууллага, хандивлагчдын олгосон хандив тусламж, гэр бүл, олон нийт, иргэдийн үүсгэл санаачилга, оролцоотойгоор хуримтлуулсан хөрөнгийн зарцуулалтыг нээлттэй олон нийтэд тогтмол мэдээлж байх;

АРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ:

Хөтөлбөр хэрэгжилтийн явц, үр дүнд аймгийн Засаг даргын Тамгын газар, Гэр бүл, Хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Эрүүл мэндийн газар, Хөдөлмөр, Халамжийн Үйлчилгээний газар, Эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагын төлөөлөл оролцсон ажлын хэсэг байгуулж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Хөтөлбөрт аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг даргын санаачилгаар хөндлөнгийн үнэлгээ хийх

АРАВ НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

№	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин /2019он/	Хүрэх түвшин	
			Жил бүр	2024 он
1.	Эмэгтэйчүүдийн ажил хөдөлмөрт зуучлагдсан хувь	12,2%	0,3	24%
2.	Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн тоо	66	79	79
3.	Гэр бүлийн хүчирхийллийг бууруулсан хувь	0,1% - 0,5% өссөн	1,2%	4,8%
4.	Эмэгтэйчүүдэд зориулсан сургалтын төвийн тоо	0	1	4
5.	Эрүүл мэндийн боловсрол олгох сургалтад хамрагдсан охид, эмэгтэйчүүдийн хувь	8%	10%	55%
6.	Гэр бүл төлөвлөлт, жендэрт суурилсан хүчирхийллийн талаар ойлголт нэмэгдүүлэх сургалтад хамрагдалтын хувь \өсвөр насны охид, эмэгтэйчүүд, ахмад настан\	8,5%	10%	55%
7.	Өсвөр үе залуу охидод эмэгтэй хүний ариун ёс журам, эх оронч үзлийг төлөвшүүлэх талаар сургалт сурталчилгааны ажлын тоо	4	6	12
8.	Хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан үйл ажиллагаанд хамрагдсан эмэгтэйчүүд хувь	5%	10%	55%

---ooOoo--